



УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны захиалга, ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Аудитын газраас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн нийцлийн аудитын тайлан.



Байгаль орчны хамгаалах тухай хуулийн хэрэгжилт хэвийн байгаа хэдий ч Засгийн газрын 2001 оны 264 дугаар тогтоолыг шинэчлүүлэх, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос зарцуулах хувь хэмжээг мөрдөөгүй байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт

2016 оны 10 сар

УБААГ-2016/11-НА

УБААГ-2016/11-НА

<u>Тайлан бэлтгэсэн:</u>	Агуулга	3
Дарга, тэргүүлэх аудитор Б.Авирмэд	Товчилсон үгийн тайлал	4
Аудитын менежер Ж.Энхжаргал	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5
Ахлах шинжээч М.Батсуурь	Бүлэг 1.	8
Аудитор С.Батсайхан	Бүлэг 2.	11
	Бүлэг 3.	13
	Бүлэг 4.	15
	Дүгнэлт	16
	Зөвлөмж	16
2016 оны 10 дугаар сар	Холбогдох байгууллагын санал	17
	Аудитын газраас өгөх тайлбар	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7045-3317, 7045-3721, 7045-4721 дугаарын утсаар харилцана уу.		
Хаяг: Увс аймгийн Аудитын газар Улаангом сум 3 дугаар баг аймгийн Засаг даргын тамгын газрын байр		

Товчилсон үгийн тайлал:

БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БОХС	Байгаль орчныг хамгаалах сан
УНАСУТХГНХЗ	Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгуудийн хамгаалалтын захиргаа
ХХНУТХГНХЗ	Хан хөхийн нурууны улсын тусгай хамгаалалттай газар нутгуудийн хамгаалалтын захиргаа

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2016 оны 01 тоот тогтоол, ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Аудитын газраас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэнд нийцлийн аудит хийлээ.

Аудитын зорилт

Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, аймгийн хэмжээнд мөрдөх шийдвэр, дүрэм, журам батлаж биелэлтийг хангуулах үйл ажиллагаа нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд нийцлийн аудит хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд хийлээ. Үүнд:

- Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймгийн ИТХ, Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан үүргийг биелүүлсэн эсэх.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлөвлөж бүрэн төвлөрүүлсэн эсэх.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан эсэх.
- Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хуульд заасны дагуу хэрэгжүүлсэн эсэх.

Хамрах хүрээ

Аудитад аймгийн ИТХ, Засаг даргын тамгын газар, БОАЖГ, сумын ИТХ, засаг дарга түүний харьяа байгууллага, бүх шатны татварын байгууллага, холбогдох аж ахуй нэгжүүдийг хамруулан хийж гүйцэтгэлээ.

Арга зүй

Аудитыг АДБОУС 100-400, 4000, 4200, төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Энэхүү нийцлийн аудитыг явуулахад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журам, нийцлийн аудитын төлөвлөгөө, асуудлын шинжилгээ, арга зүйг мөрдөж ажиллалаа.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлт, зөвлөмжид дэмжлэг болохуйц нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Нийцлийн аудитыг аймгийн Аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Авирмэд хянан удирдаж, аудитын менежер Ж.Энхжаргал аудитын стандартыг хангуулж, ахлах шинжээч М.Батсуурь, аудитор С.Батсайхан нар 2016 оны 9-р сарын 05–наас 10-р сарын 10-ны хооронд ажлын 26 өдөрт хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрхэм зорилго нь “эдийн засаг, нийгмийн хөгжлийн хандлагыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлж, байгалын нөөц баялагийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргээх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино” гэж тодорхойлогдсон байна.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүрээлэн буй орчны бохирдол, доройтолыг бууруулах, байгалийн баялгийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг олон нийтийн оролцоо, хяналтанд тулгуурлан зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх, ойн талаар төрөөс баримтлах бодлого, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, газар зохион байгуулалт болон усны талаарх бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, салбарын бодлого төлөвлөлт, бодлогын хэрэгжилтэнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлж, дүгнэлт, зөвлөмж гаргах, үнэлгээний талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах чиг үүрэгтэй байна.

2015 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 271,6 сая төгрөг төвлөрүүлснээс 82,3 сая төгрөгийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан байна.

Усны тухай хуулийн 17.1.4-д “Сав газрын захиргаа нь усны тоо бүртгэлийг жил бүр сав газрын хэмжээнд нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах” гэж заасны дагуу Увс нуур Тэс голын сав газрын захиргаа нь 2013 оноос эхлэн жил бүр сав газрын усны тоо бүртгэлийг орон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран зохион байгуулж ирсэн байна.

Усны тоо бүртгэлийн журмын 9-д “усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, усны хөнөөлөөс урьдчилан сэргийлэх төрийн бодлогыг тодорхойлоход ашиглах, аймаг дамжин орших хийгээд урсах усны ашиглалтыг зохицуулах, усны нөөцийн экологийн тэнцлийг хадгалах зорилгоор усны улсын тоо бүртгэлийг 5 жилд 1 удаа явуулна” гэж заасны дагуу Байгаль орчин аялал жуулчлалын газар 2003, 2007, 2011 онуудад усны тооллогыг явуулсан байна.


Аудитын хүрээнд БОАЖГ, УНАСУТХГНХЗахиргаа, ХХНУТХГНХЗахиргаа, Өндөрхангай, Түргэн сумын Ойн анги, болон 11 суманд томилолтоор очиж ажилласан.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17.1.1-д “нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих” гэж заасны дагуу аймгийн ИТХ-ын 2014 оны 11 дүгээр сарын 28 өдрийн 8/05 дугаар тогтоолоор ойжуулалт болон ойн зурвас байгуулахад 20.0 сая, булаг шандын эх хамгаалахад 10.9 сая, байгалийн орчны нөлөөллийн үнэлгээ, аудитын эрх зүйн орчны шинэчлэлийн талаарх болон бусад чиглэлийн сургалт сурталчилгааны ажил зохион байгуулахад 4.0 сая, төв суурин газрын худаг, ус цэгийн тооллого явуулах, бүртгэлжүүлэх, чанарын шинжилгээ хийлгэхэд 3.0 сая, ерөнхий агнуурын зохион байгуулалтанд 30.0 сая байгаль хамгаалагчдийн дүрэмт хувцас хийлгэхэд 5.0 сая, мод үржүүлгийн газар байгуулахад 10.0 сая, нийт 82.9 сая төгрөг баталсан байна.


Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17.1.2-д “нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоох” гэж заасны дагуу аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 11 дүгээр сарын 29-ний 8/08 дугаар тогтоолоор 2015 онд бэлтгэж ашиглах түлш, хэрэглээний модны дээд хэмжээг баталжээ.



Увс аймгийн Сагил, Бөхмөрөн сумын хил залгаа улсын хил орчмын 126772 га газар нутгийг ховор амьтан ургамлын нөөц нутаг, нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежментийг хэрэгжүүлэх түшиц газраар анх 2008 онд аймгийн ИТХ-ын тогтоолоор Гулзат нэрээр орон нутгийн хамгаалалтанд авсан байна. Улмаар нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгааллын бодлогыг хэрэгжүүлж байгалийн тодорхой төрлийн байгалийн нөөц баялагийг менежментийн нөхөрлөлүүдэд хариуцуулан хамгаалуулснаар тогтвортой хамгаалал бий болж, биологийн төрөл зүйлийн зүй зохистой ашиглалт хамгаалалтын бодлого үр дүнтэй хэрэгжсэнээр Гулзат орон нутгийн хамгаалалттай газарт байршил бүхий ховор амьтан аргаль хонь, хар сүүлт зээрийн тоо толгой өсөж тархац нутгийг тэлсэн байна. Иймээс 2015 онд аймгийн ИТХ-ын 9/04 тоот тогтоолоор Гулзат орон нутгийн хамгаалалттай газрыг 215995 га болгож өргөтгөсөн байна. Мөн Гулзат ОНХГ-ын менежментийн төлөвлөгөө /2015-2019 он/-г Увс аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 03 сарын 26 ны өдрийн А/38 тоот тогтоолоор баталуулан хэрэгжүүлж байна.



Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 04-ний А/426 тоот “Улсын хэмжээнд тусгай болон ахуйн зориулалтаар амьтан агнах, барих хуваарь батлах тухай” тушаалаар нийт 12 аймгийн 35 суманд 40 тооны аргаль агнуулах зөвшөөрөл олгосноос Увс аймагт Бөхмөрөн суманд 2, Сагил суманд 2, нийт 4 аргаль агнажээ.



Амьтны тухай хууль, Засгийн газрын 2013 оны 93 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу Гулзат орон нутгийн хамгаалалттай газрын агнуурын менежментийг байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийн 100 хувийн гишүүнчлэлтэй “Гулзатын санаачилга” ТББ хариуцан ан агнуурын менежмент төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.3. Аймгийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төлөвлөгөө боловсруулж, бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллажээ.

Ойн тухай хуулийн 13.1.18-д Төрийн захиргааны төв байгууллага “аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ”, 17.2.10-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга ой бүхий сум, дүүргийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих эрхтэй” гэж заажээ.

Увс аймгийн 2011-2015 онд хэрэгжүүлэх ойн менежментийн төлөвлөгөөг аймгийн БОАЖГ-ын ойн албаны мэргэжилтнүүд боловсруулан БОАЖГ-ын даргаар хянуулан аймгийн Засаг даргад танилцуулж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн А-156 тоот тушаалаар батлуулжээ.

Аймгийн “Ойн менежментийн төлөвлөгөө”-ний 2.2-д ойжуулалт, байгалийн сэргэн ургалтанд туслах, тарьц суулгац ургуулах талаар тодорхой тусгасан байна.

Аймгийн Байгаль орчны газар болон Засгийн газрын 2012 оны 255 тоот тогтоолоор “Ойн нөөц, төлөв байдал, ашиглалтын эрчимжилтээс хамаарсан аймаг, нийслэлд байгуулагдах сум дундын ойн ангийн хариуцах талбайн норматив, байршил” тогтоосон байна.

Дээрх тогтоолын дагуу манай аймагт Хангайн нурууны ойн аж ахуйн муж Өндөрхангай суманд, Монгол алтайн ойн аж ахуйн муж Түргэн суманд тус бүр Сум дундын ойн ангийг байгуулсан байна.

Түүнчлэн Малчин сумын ИТХ-ын дарга 2014 оны 03 тоот албан бичгээр аймгийн ИТХ-д, сумын Засаг даргын 2014 оны 38 тоот бичгээр аймгийн Засаг даргад хандаж Малчин суманд Наранбулаг, Малчин, Хяргас сумдыг харьяалсан Сум дундын ойн ангийг байгуулж өгөх хүсэлт гаргасны дагуу 2015 оны 5 сард Ойн анги байгуулсан байна.

Мөн 2013 онд аймгийн хэмжээнд 13 ойн мэргэжлийн байгууллага шалгалтанд хамрагдснаас 11 байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгаж, 2014 онд 2 байгууллага шинээр эрх авсан байна. Аймгийн хэмжээнд байгаль орчны чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг 68 нөхөрлөл байгуулагдан ажиллаж байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 тушаалаар баталсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам”-ын 4.1-д Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ. Мод бэлтгэдэг үйл ажиллагаа эрхэлдэг нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн хөрөнгөөр ойжуулалтын ажлыг гүйцэтгэнэ” гэж заажээ.

Аймгийн хэмжээнд мод бэлтгэлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий мэргэжлийн 4 байгууллага байна.

Байгаль орчны газраас 1 модыг 3 жил арчилж ургуулах зардлыг тооцоолсны дагуу аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2012 оны 4 сарын 12-ны А/36 тоот тогтоолоор 1 модны тарифыг 6250 төгрөг байхаар тогтоосон байна.

Увс нуур-Тэс голын сав газрын захиргаа, Байгаль орчин аялал жуулчлалын газрууд нь усны талаарх үндсэн чиг үүргийг гүйцэтгэдэг бөгөөд Ус цаг уур орчны шинжилгээний алба, Мэргэжлийн хяналтын газарт усны чанарын хяналтын лаборатори ажиллаж байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.2.5-д “нутаг дэвсгэртээ ажиллах байгаль орчны улсын ахлах болон улсын байцаагчийг энэ хуульд заасны дагуу ялгах тэмдэг, дүрэмт хувцас, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар хангах” гэж заасны дагуу Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас өвлийн хувцас болон унаагаар хангаж байжээ

Хувцас нь 2 жилийн хугацаатай байдаг ба 2015 онд аймгийн БОАЖГ –ын 5 мэргэжилтэн, сумдын 32 байгаль хамгаалагч нийт 37 ажилтныг зуны хувцасаар хангасан байна.

БҮЛЭГ 2: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлөвлөж, бүрэн төвлөрүүлсэн байна.

2.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17.1.2-д “нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг энэ хуульд заасан

үндэслэл, журмын дагуу тогтоох” гэж заасны дагуу аймгийн ИТХ-ын 2014 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 8/05 тоот тогтоолоор 2015 онд ус ашигласны төлбөрийн орлогоос 31.6 сая төгрөг, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 68.9 сая төгрөг, ан амьтаны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 149.8 сая төгрөгийг төсөвт оруулахаар төлөвлөн баталжээ.

Увс аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын захиалгаар ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгааны ажлын тайлан, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг “Эко үйлчилгээ”-ний ТББ-аар гаргуулжээ. Уг төлөвлөгөөг үндэслэн 2015 онд Увс аймагт 4 аргаль агнах зөвшөөрөл олгожээ.

Аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын санал дүгнэлтийг үндэслэн элбэг ангийн нарийвчилсан агнуур зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөг 2016 онд боловсруулж батлуулжээ.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 12.1.6-д “гадаадын иргэнд агнуулсан болон гадаад улсад амьдаар нь аливаа зориулалтаар гаргасан ан амьтны төлбөрийг тухайн ан олзворын гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнээр” гэж заасан байхад Засгийн газрын 2001 оны 264 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтад аргалийг 18,0 мянган долларын үнэлгээгээг баримтлан агнуулж байгаа нь дэлхийн зах зээлийн үнэлгээтэй уялдахгүй байна. Иймд зах зээлийн ханшийг судалж, холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрүүлэхийг зөвлөмж болгов.

2014 оны 11-р сарын 21-нд Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохуй төслөөс сум, аймаг, үндэсний түвшинд хэлэлцэн боловсруулсан Увс нуур-Тэс голын сав газрын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулжээ.

2.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрүүлсэн байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17.1.2-д “нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоох” гэж заажээ. Үүний дагуу аймгийн ИТХ-ын 2014 оны 11 дүгээр сарын 28-ны 8/05 тоот тогтоолоор 2015 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг нэр төрөл тус бүрээр төлөвлөснийг 10-11 хувиар давуулан биелүүлжээ. Дээрх орлогын нэр төрлийг төлөвлөгөө, гүйцэтгэлээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

/мян.төг/

№	Байгалын нөөц ашигласны төлбөрийн нэр	2015 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	31600,0	35380,2	3780,2
2	Ойн нөөц ашигласны төлбөр	68999,9	69341,4	341,5
3	Ан, амьтаны нөөц ашигласны төлбөр	149800,0	166935,6	17135,6
	Нийт дүн	250399,9	271657,2	21257,3

БҮЛЭГ 3: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан байна.

3.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээг хуульд заасан хэмжээнээс дутуу баталж өгсөн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтоожээ.

Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төрөл	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаар /нийт орлогын дүнгээс хувиар/
1. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	50 хувь
2. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	85 хувь
3. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	35 хувь

Аймгийн ИТХ-ын 2014 оны 11 дүгээр сарын 28 өдрийн 8/05 дугаар тогтоолоор батлагдсан орлогоос 2015 онд дараах орлого бүрдүүлсэн байна.

Д/д	Орлогын нэр төрөл	Орлогын дүн /гүйцэтгэл/	Хувиарлавал зохих дүн	Хувиарласан дүн	/мян.төг/ Зөрүү
1	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	166935,6	64919,2	39000,0	25919,2
2	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	69341,4	58940,2	30000,0	28940,2
3	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	35380,2	12383,1	13975,0	-1591,9
	ДҮН	271657,2	136242,5	82975,0	53267,5

Ан амьтан нөөц ашигласны төлбөрийн орлогоос 64,9 сая төгрөг хуваарилагдах байсан боловч Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь хэмжээг баримтлахгүйгээр 39,0 сая төгрөг хуваарилж 44,5 сая дутуу, Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 58,9 сая төгрөг хуваарилагдах байсан боловч 30,0 сая төгрөг хувиарлаж 28,9 сая дутуу хуваарилсан байна.

Харин ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 12,4 сая төгрөг хуваарилагдах байсан боловч 13,9 сая төгрөг хуваарилж 1,6 сая төгрөгийн илүү хуваарилсан байна.

Иймд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь хэмжээг баримтлан хуваарилж байхыг зөвлөмж болгов.

3.2. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.3-д заасан арга хэмжээнд зарцуулсан байна.

2015 онд Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 69,3 сая төгрөг төвлөрүүлсэн. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу 30,0 сая төгрөг хуваарилснаас ойжуулалт ойн зурвас байгуулахад 14,0 сая төгрөг, мод үржүүлгийн газар зохион байгуулахад 7,6 сая төгрөг, нийт 21,6 сая төгрөгийг Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.3.4-д заасан арга хэмжээнд зарцуулжээ. Үлдэгдэл 8,4 сая төгрөгийг зарцуулах эрхийг нээхгүйгээр буцаан төвлөрүүлсэн байна.

3.3. Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.2-д заасан арга хэмжээнд зарцуулсан байна.

2015 онд Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 35,4 сая төгрөг төвлөрүүлсэн. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу 13,9 сая төгрөг хуваарилснаас Малчин, Тариалан, Улаангом сумын 5 булаг шанд тохижуулахад 11,0 сая төгрөг, төв суурин газрын худаг, ус цэгийн тооллого явуулах, бүртгэлжүүлэх, чанарын шинжилгээ хийлгэхэд 1,1 сая төгрөг, нийт 12,1 сая төгрөгийг Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.2.1, 3.2.5-д заасан арга хэмжээнд зарцуулжээ. Үлдэгдэл 1,8 сая төгрөгийг зарцуулах эрхийг нээхгүйгээр буцаан төвлөрүүлсэн байна.

3.4. Байгалийн ургамал, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.1, 3.4-д заасан арга хэмжээнд зарцуулсан байна.

2015 онд ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 166,9 сая төгрөг төвлөрүүлжээ. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу 39,0 сая төгрөг хуваарилснаас ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгаа хийлгэхэд 28,6 сая төгрөг, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, аудитын эрх зүйн орчны шинэчлэлийн талаарх болон бусад чиглэлийн сургалт сурталчилгааны ажил зохион байгуулахад 1,5 сая төгрөг, нийт 30,1 сая төгрөгийг Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.4.1, 3.4.3-д заасан арга хэмжээнд зарцуулжээ. Үлдэгдэл 8,9 сая төгрөгийг зарцуулах эрхийг нээхгүйгээр буцаан төвлөрүүлсэн байна.

Байгалийн ургамлын тухай хуулийн 7.1-д “Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа ургамлын тархац, нөөцийн судалгааг 5 жил тутамд төрийн захиргааны төв байгууллага, шинжлэх ухааны байгууллагатай хамтран явуулна” гэж заажээ. Орон нутагт нөөц тогтоогоогүй учраас ургамал ашиглах зөвшөөрөл олгогдоогүй байна.

3.5. Байгалийн нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлээгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 19-22 дугаар зүйлд заасны дагуу хөнгөлөлт чөлөөлөлтийг үзүүлээгүй байна.

БҮЛЭГ 4: Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хийх дотоод хяналтын тогтолцоо орон нутагт бүрдээгүй байна.

4.1. Хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрждээ.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15.2.2-т “салбартаа байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж үр дүнг жил бүр Засгийн газарт тайлагнах”, Усны тухай хуулийн 10.1.21-д “сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн байгаль хамгаалагчийг усны харилцааны талаарх нэгдмэл удирдлагаар хангах, энэ хуулийн 28.4-т заасны дагуу гаргасан сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны албаны дүгнэлт, түүнчлэн усны мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд хяналт тавих” гэж заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт шинжилгээ, дотоод аудитын газар ажиллаж байна.

4.2. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих дотоод нэгжээс хяналтыг тавьж ажилласан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт шинжилгээ, дотоод аудитын газар нь улирал бүр тайлан мэдээ авах, 2015 онд 29 усны дүгнэлтийг файлаар авч хяналт тавих ажлуудыг хийжээ. Ан агнуурын хувьд “Гулзатын санаачлага” ТББ агнах үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- *Засгийн 2001 оны 264 дүгээр тогтоолыг баримтлан үнэлгээ тогтоож байгаа нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 12.1.6 дахь заасантай уялдахгүй байна.*
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээг мөрдөөгүй байна.

Зөвлөмж:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд:

- Засгийн газрын 2001 оны 264 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтанд тусгагдсан аргалийн үнэлгээг зах зээлийн үнэлгээтэй уялдуулан өөрчлөх асуудлыг судалж, шийдвэрүүлэх.

Байгаль орчин, аялал жуулчлалын газарт:

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээг мөрдөн батлуулж байх.

Холбогдох байгууллагын санал



Холбогдох байгууллагын ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Тайлангийн төсөлтэй санал нэг байна гэсэн албан тоот ирсэн тул хариу тайлбар өгөх шаардлагагүй.

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ ШИНЖЭЭЧ
АУДИТОР

М.БАТСУУРЬ
С.БАТСАЙХАН